

МОНГОЛЫН НИЙГМИЙН ОЮУН САНААНЫ АМЬДРАЛ БА МҮОНТ

Д.Нарантуяа*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: нийгмийн оюун санааны амьдрал, телевизийн нөлөөллийн чадамж, шинэ медиа, нэвтрүүлгийн бодлого, бичлэгийн төрөл зүйл, нэвтрүүлгийн үр нөлөө.

Хүн төрөлхтний оюун санааны амьдралд, хувьсал дэвшил авчирэн үргэлжилсэн хэвлэх үйлдвэр, ном, сонин, сэтгүүл, радио, телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, интернэт, гар утас, сошиал медиа платформууд бүгд өөрийн гэсэн цаг үетэй, тухайн цаг үеийнхээ нийгмийн амьдрал, оюун санааны амьдралд тодорхой өөрчлөлтүүдийг эхлүүлсэн өөрийн гэсэн хөгжил дэвшлийн түүхтэй байдаг. Гэсэн ч хэвлэл мэдээллийн салбарын шинэ үзэгдэл үйл явц бүгдийн түүх нэг ижил цэгт уулздаг. Тэр цэг бол үүрэг хариуцлагын цэг юм. Тодруулбал, сонин сэтгүүл ч тэр, радио телевиз ч тэр, нийгмийн сүлжээний шинэ платформууд ч тэр бүгд тухайн цаг үеийнхээ, тухайн нийгмийнхээ оюун санааны амьдралын идэвхтэй оролцогч, хүчтэй нөлөөлөгч, зарим талаар чиглүүлэгч нь болж, тодорхой үүрэг гүйцэтгэсээр ирсэн, цаашид ч энэ үүрэг хариуцлага үргэлжлэх нь ойлгомжтой юм. Тэгэхээр нийгмийн салбар шинжлэх ухааны нэгэн төлөөлөл болох сэтгүүл зүйн шинжлэх ухаан нь тухайн нийг-

мийнхээ оюун санааны амьдралын хөгжил төлөвшлийг тодорхойлогчдын нэг байсаар ирсэн, цаашид ч тийм байна гэсэн үг. Тиймээс энэхүү тойм өгүүллээрээ ХХ зууны Монголын нийгмийн оюун санааны амьдралд үзэгдэл болж, хөгжил дэвшил болж анх үүсэн байгуулагдсан телевизийн түүхэн үүрэг нөлөөллийг тодруулан харж, мэдээллийн технологийн хөгжлийн хурд, шинэ медиа хөгжлийн орчин үеийн олон талт чиг хандлага бүхий өнөө цагийн, хуулиар хүлээсэн үүрэгтэй, олон нийтийн статустай МҮОНТ-ийн бодлого үйл ажиллагаа, нөлөөллийн чадамжтай харьцуулан үзэхийг зорилгоо болголоо.

Улс орны хөгжил, нийгмийн оюун санааны амьдралд сэтгүүл зүйн салбар тэр дундаа сонин, сэтгүүл, радио, телевиз тус бүрийн гүйцэтгэж байсан хийгээд одоогийн үүрэг оролцоо, нөлөөллийн чадамжийг тодорхойлох арга зам нь тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн “нийгмийн оюун санааны амьдралд эзлэх байр суурь, хүлээн зөвшөөрөгдөх хийгээд хэр үнэ цэнэтэй, эрэлт хэрэгцээтэй байгаа”-гаар хэмжихээс өөр хэмжүүр шалгуур үзүүлэлт үгүй юм. Энэ санааг батлах мэт МҮОНТ-ийн нэгэн үеийн түүхийн номд, “Монголын зурагт радио албан ёсоор нээлтээ хийсэн тэр цагаас хойш Монгол телевиз нь төр, засгийн бодлогыг олон түмэнд

тайлбарлан таниулагч, түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжин туслагч, хөдөлмөрчдийн бүтээлч, идэвхийг өрнүүлэн зохион байгуулагч, тэдний соёл хүмүүжлийн дотно зөвлөгч, үлгэрлэн дагуулагч, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, суралцах, танин мэдэх, чухал хэрэгсэл болсоор ирсэн” (MNB, 1997) хэмээх бичигджээ. Тэгэхээр өнгөрөгч зууны телевизийн түүх тэр чигтээ улс орны хөгжлийн түүх, нийгмийн оюун санааны амьдралын салшгүй нэг хэсэг нь байжээ. Телевизийн үүрэг оролцоо, үнэ цэнэ, эрэлт хэрэгцээ итгүүлэн үнэмшүүлэх чадамж өндөр байсан нь хэд хэдэн учир шалтгаантай. Хамгийн эхэнд улс орон даяар ганцхан телевизтэй байсан явдал нөлөөлж байсан бол хоёрдугаарт, тухайн цаг үед сэтгүүл зүйн хөгжлийн түүхэн дэх шинэлэг үзэгдэл нь телевиз болж байсан явдал, гуравдугаарт дэлхийтэй харьцуулан харвал Монголын нийгмийн оюун санааны амьдралын эрэлт хэрэгцээнд телевиз шиг хүчтэй нөлөөлөх соёлын өөр салбар тэгтлээ их хурдтай хөгжчихөөгүй байсан гэдгийг харж болно. Сонин, сэтгүүл, радио, кино, театруудын аль нь ч телевизийн өрсөлдөгч биш хамтрагч нь байсан.

Ингэж дан ганц сэтгүүл зүйд төдийгүй улс орны хөгжилд, нийгмийн амьдралд, шинэ үзэгдэл болж телевиз байгуулагдсанаар, Монголын нийгмийн оюун санааны амьдралыг хүний, байгууллагын, төр засгийн үйл ажиллагаагаар дамжуулан дүрсжүүлж, баримтжуулж, хадгалан дамжуулж, биежүүлэн үзүүлэх, өвлүүлэн үлдээх цоо шинэ замналыг эхлүүлсэн байдаг. Итгүүлэн үнэмшүүлэх чанараараа бусад ХМХ-ээс давуу талтай гэгддэг телевизийн нийгмийн оюун санааны амьдралд эзлэх байр суурийг тухайн цаг үедээ бэлтгэн

үзүүлж байсан нэвтрүүлгүүдийн хүмүүст нөлөөлж байсан нөлөөллөөр, хүмүүсийн оюун санаанд түгээж байсан үзэл санаа, бий болгож байсан хүсэл тэмүүлэл, ирээдүйн зорилготой болоход хүргэсэн сэдэл санаануудаар тодорхойлж болно.

Зурагт радио нэрээр анх байгуулагдсан МҮОНТ-ийн Монголын нийгмийн оюун санааны амьдралд эзлэх байр суурийг тодорхойлохдоо 1967-1970, 1970-1980, 1980-1990 ба 1990-2005, 2005 оноос хойш гэсэн таван бүлэгт хуваан авч үзэх нь байгууллагын хөгжлийн бодлого үйл ажиллагаа, хөтөлбөрийн агуулга зорилгын нийгэм хүмүүст нөлөөлөх нөлөөллийг тодруулах түүх, баримт гэдэг утгыг илүү хангана.

1967-1970 он гэхэд, Монголын зурагт радиогоор хот хөдөөгийн залуусын хүмүүжил соёл, бие бялдрын хөгжил, оюун санааны итгэл үнэмшлийн манлайллыг бий болгох зорилготой Авхаалжит сэргэлэнчүүдийн клуб буюу “АСК” нэвтрүүлэг, залуусын үзэл бодол, зорилго мөрөөдлийг дэмжин таниулах “Манай гарагийн залуус” нэвтрүүлэг, хөдөлмөрийн алдар цуутнуудыг сурталчлан таниулах, ажлын мэдлэг туршлага солилцох, харилцан суралцах, үлгэр дуурайлал бий болгох зорилготой “Ард овогтой хүн”, “Төрийн шагналтан” хөрөг нэвтрүүлгүүд, ажил амьдралаа эрүүл соёлтой авч явах арга ухааныг заан таниулах зорилготой “Эрүүл энхийн сургууль”, “Ашигтай зөвлөгөө”, “Бүхнийг хүний төлөө” зэрэг нэвтрүүлгүүд, хөгжөөнт цэнгээнт, амралт чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд хөтөлсөн “Цэнхэр дэлгэц” цэнгээнт нэвтрүүлэг, монгол ардын эртний бодлого бодуулах, оньс тайлуулах зэргээр уламжлалт ухаанаас суралцахыг эрхэмлэсэн “Таны амралтад”

нэвтрүүлэг, тухайн үеийнхээ улс орны амьдралд тод үзэгдэл болж байсан нийтээрээ соёлжих зорилгын утга мөн чанарыг зөв таниулах, түгээн дэлгэрүүлэх, орон гэр орчин тойрондоо цэвэр цэмцгэр амьдралыг бий болгох ахуйн соёл төдийгүй урлаг соёлд дурлах сэтгэлгээний соёл, эрдэм ухаанд дурлах оюуны соёл танин мэдэхүйн зорилготой “Соёл эрдэнэ” нэвтрүүлэг, хүүхэд залуусын мэдлэгт өнгөрсөн одоо ирээдүйн тухай бодол ухаарал нэмэх зорилготой “Борхүүгийн зүүд”, “Гахайн гурван торой”, “Түүдгийн гал”, “Хоньчин Найдан”, “Хүжийн гал” зохиомжууд, анхны богино хэмжээний теле жүжиг “Сүүн цагаан сэтгэл”, анхны бүрэн хэмжээний “Жаргалыг хүссэн Мөнхөө” жүжиг, алдаа оноог дэнслэн ойлгуулах зорилготой “Тоншуулаар сонин юутайв”, “Хошин шогчдын клуб” нэвтрүүлгүүд, танин мэдэхүйн төрлийн “Кино дэлгэц”, “Кино аялал”, “Амьтны ертөнц” нэвтрүүлгүүд, ерөөс сургалтын зорилготой “Хөдөлмөрчдийн улс төрийн боловсролд”, “Залуу зураачдад өгөх зөвлөгөө”, “Хөгжмийн боловсролд”, “Урлаг уран зохиолын таавар” нэвтрүүлгүүд, телевизийн анхны баримтат кино болох “Монгол уянга” зэргийг бүтээж алтан сан хөмрөгт хадгалуулсан байна.

Эндээс харахад, шинэ тутам байгуулагдсан, телевизийн салбарын мэдлэг туршлагагүй, мэргэжлийн уран бүтээлчид, ажилтан ажилчид дутмаг, техник технологийн боломж бага, хангамж тааруу 1967-1970 оны Монголын зурагт радиогийнхны хувьд нийгмийн амьдралын бүхий л салбар, нэгж, иргэд, гэр бүлийн гишүүн бүрд хүрэх нэвтрүүлгийн бодлого чиглэл барьж, сэтгүүл зүйн бичлэгийн чамгүй олон төрлийг эхлүүлж, чамламгүй олон сэдвийг анхаарч, өнөөгийн

МҮОНТ-ийн бодлого үйл ажиллагааны үндэс суурийг тавьсан төдийгүй сэтгүүл зүйн салбарын томоохон төлөөлөл болох телевизийн үндсэн үзэл хандлагыг бүрдүүлэн өгч чадсан байна. Ахмад уран бүтээлчдийн дурсамжаас үзэхэд дэлгэцээр гарц буй эфирийн 50 хувь нь хальсыг гараар эргүүлж, тасалдуулахгүйгээр хооронд нь эвлүүлэх байдлаар ар араас нь холбодог гар ажиллагаатай байсан 1967-1970 оны телевизийн уран бүтээлчид инженер техникийн ажилчдын хичээл зүтгэл, хоёргүй сэтгэлийн хөрс суурин дээр МНВ цэцэглэн хөгжсөн гэдэг нь маргашгүй юм.

1970-1980 он гэхэд, Ардын хувьсгалын 50 жилийн ойн ажлын хүрээнд “Зурагт радиогийн хөгжлийг шинэ шатанд гаргах” зорилго тавигдахтай зэрэгцэн ЗХУ-д бэлтгэсэн мэргэжлийн хүмүүсийн эхний ээлж сургуулиа төгсөн ирцгээж, хүний нөөцийн хувьд чадавхжиж эхэлсэн, техник төхөөрөмжийн хувьд ч ахиж дэвшсэн бөгөөд 1970 онд Зурагт радио гэдэг нэрээ сольж, “Монгол телевиз” болгосон байдаг. Мөн энэ онд Орбит станц байгуулагдаж, Зөвлөлтийн телевизээр дамжуулан Орос улсын урлаг соёл, шинжлэх ухааны мэдлэгтэй танилцах, дэлхийн бусад улс орнуудын тухай үзэж сонирхох боломж ч нээгджээ. 1971 оны нэгдүгээр сард Телекино үйлдвэр байгуулагдаж, дуу дүрс хоёрыг хамтад нь авдаг камертай болж, “Лотос” явуулын станц ашиглалтад орж, 1972 оны 12 дугаар сард “Интервидение” олон улсын телевизийн байгууллагын гишүүн болж, Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Сайншанд, Мөрөн хотуудад нэвтрүүлгүүдээ зөөн үзүүлж эхэлсэн бол удалгүй “Экран ЧМ” станц байгуулагдаж, Өндөрхаан, Баруун урт, Даланзадгад, Ховд, Улаангом, Цэцэрлэг, Зүүнхараа зэргээр хөдөө орон нутагт систем-

тэйгээр нэвтэрч эхэлсэн байна. 1976 онд зарим нэвтрүүлгээ, 1981 онд бүрэн өнгөт болгожээ. Энэ арван жилд АСК, “Цэнхэр дэлгэц”, “Манай гарагийн залуус”, “Соёл эрдэнэ” нэвтрүүлгүүд үргэлжилж, залуусын урлаг соёл, амралт чөлөөт цагт зориулсан “Солонго”, “Цэнхэр дөл” хөгжмийн нэвтрүүлэг, “Оноо хурд хурам” цэнгээнт нэвтрүүлэг, “Хи хи хи”, “Далан худалчийн клуб”, “Алиа Тогмид”, “Соёлын аян”, “Дохио”, “Манай үзлэгээр”, “Теле дуран”, “Теле тоншуул” зэрэг алиа шог, хошин шүүмжийн нэвтрүүлэг, “Бүжингийн театр”, “Хөвгүүд”, “Бүсгүйчүүд”, “18-ын клуб”, “Авьяастан залуусын клуб”, “Үе тэнгийнхэн”, “Теле уулзалт” зэрэг хүүхэд залуусын хүмүүжил ёс суртахууны төлөвшилд зориулсан нэвтрүүлгүүд, урлаг соёлын боловсрол дээшлүүлж, урлагийг хөхиүлэн дэмжсэн “Дуу бүхэн түүхтэй”, “Хөгжмийн сүлжээ” нэвтрүүлэг, иргэд олон нийттэй харилцаа үүсгэж, тэдний санал хүсэлтийг хүлээн авах нэвтрүүлэх зорилготой “Хүсэлтийн хариу”, “Захидлын мөрөөр” зэрэг нэвтрүүлгүүд, улс орны өнцөг булан бүрд хүрч ажиллах зорилгын хүрээнд 18 аймгийг бүсчлэн хувааж зургаан дугаар болгосон “Монголын сайхан орон” цуврал нэвтрүүлэг, иргэд олон нийтийн ажил амьдралыг үзүүлэх зорилготой “Энхжаргалын төлөө тэмцэгчид”, “Өнөөгийн Монголын өнгө жавхаа”, “Хөдөлмөрийн алдар”, “Гавьяа”, “Хөдөлмөр зол, жаргал”, “Одонт тугийн эзэд” нэвтрүүлгүүд, хүүхэд залуусын хүсэл мөрөөдлийг сэдэлжүүлэх зорилготой “Бид Артект очно”, “Нэвтрүүлэх танхим”, “Залуучууд дэлгэцнээ” нэвтрүүлгүүд, сургалт танин мэдэхүйн “1:6=?”, Улаанбаатар хотынхны ажил амьдралыг харуулсан, нийслэл хотын хөгжил, соёл байдлыг илэрхийлэн үзүүлэх зорилготой “Нийслэл нийслэлийнхэн” нэвтрүү-

лэг, мэдээ мэдээлэл, цаг үеийн үйл явдлын “Цаг үе үйл явдал” нэвтрүүлгүүд шинээр мэндэлж, үзэгчдээс өндөр үнэлгээ авсан “Шаргын говийн Жанжаа”, “Адуучны жаргал”, “Эцгээс өвлөсөн эрдэм”, “Өрхийн тэргүүлэгч”, “Айлыг авч явах ухаан”, “Зам дагасан хүн”, “Хос жигүүр” зэрэг теле найрууллууд алтан сан хөмрөгт хадгалагдан үлдсэн байна. 1970-1980 оны хооронд тэр үеийн Монгол телевизийн улс орны хөгжил, нийгмийн амьдрал, нийтийн ухамсар сэтгэлгээ, нийгмийн оюун санааны амьдралд хүчтэй нөлөөлж, томоохон үүрэг гүйцэтгэж байсныг батлах олон жишээнээс нэгийг сонгон дурдвал, энэ арван жилд анхлан бий болсон цоо шинэ төрөл болох “теле дуудлага” хэмээх төрлийн нэвтрүүлгүүд юм. Теле дуудлага нь хэлбэрийн хувьд ч агуулгын хувьд шинэлэг хийгээд нэвтрүүлгийн дараах үр нөлөө, гарах үр дүнгийн хувьд нэлээд ач тустай нэвтрүүлэг байжээ.

“Э х орон дуудсан цагт” гэсэн сэдвээр “Залуучуудын үнэн” сонинтой, “Талбай амарч байх хооронд” гэсэн сэдвээр “Үнэн” сонинтой, үйлдвэрийн сэдвээр олон нийтийн байгууллагатай, зарим яам тамгын газар, хууль хяналтын байгууллагатай хамтарсан дуудлага хийсэн байдаг нь нэг талаас төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүч түрэн оролцсон мэт. Өөр талаас харвал төр улсын ажил, нийгмийн асуудал, үүрэг хариуцлагыг хангах талд анхааран ажиллаж, сэтгүүл зүйн “хоточ нохой” байх үүргээ биелүүлсэн байдаг. Тухайн жилүүдэд телевизийн салбарт шүүмжлэлт сэтгүүл зүйн хөрс суурь тавигдсан ч гэж дүгнэж болохоор юм. Гагцхүү нэг намын үзэл суртлын үүднээс дангаараа ноёрхох ганц телевизийн дуранг зэвсэг болгон ашиглах хандлага байсан эсэхэд

анхаарах хэрэгтэй юм. Төл хүлээн авах, хадлан хадах, тариа ногоо хураах, зэрэг хавар намрын их ажлыг хамтын хүчээр цаг алдалгүй, хохирол багатай хийж дуусгах санаачилгууд гаргаж, телевизийн нэрэмжит уралдаан зарлаж, “Ургачын талбайгаас үзүүлж байна” зэрэг нэвтрүүлэг бэлтгэж байсан. Улаанбаатарын болон Дарханы тоосгоны завод, авто тээврийн зарим бааз зэрэг ижил төстэй үйл ажиллагаатай байгууллагуудын хооронд уралдаан зарлаж байсан зэргийг харвал улс орны хөгжлийг урагшлуулахад телевизийг ихээхэн түлхэц болгон ашиглаж эхэлжээ гэж дүгнэх үндэстэй юм.

Мөн энэ хугацаанд буюу 1978 онд Эрдэнэт үйлдвэр ашиглалтад орсныг шууд дамжуулсан нь орон нутагтай холбогдсон анхны том шууд дамжуулалт байсан. Эргээд энэ бүх мэдээллийг дүгнэн харвал, телевиз байгуулагдсан цагаасаа хойш 10 гаруй жилийн дотор хурдтай хөгжиж, хүн хүч хийгээд бодлого үйл ажиллагаа, техник төхөөрөмжийн хувьд мэргэжлийн чиг хандлагатай хэвлэл мэдээллийн байгууллага болон төлөвшиж чаджээ. Энэ тухайд “Нэгдүгээрт, урьдаас бэлтгэсэн дэс дараалалтай нэвтрүүлгүүд хийх, хоёрдугаарт, мэргэжлийн уран бүтээлчид, туршлагатай сэтгэлтэй ажилтнуудынхаа хүчийг анхаарал татсан сэдвүүд, гол үйл явдлуудад зөв хуваарилах, гуравдугаарт, улс нийгмийнхээ хөгжилд хувь нэмрээ оруулж буй хөдөлмөрийн хүнийг тод томруун харуулсан теле найруулал, улс орныхоо эрт эдүгээгийн амьдрал хөгжлийн замналыг зэрэгцүүлэн үзүүлэх теле нийтлэл, итгүүлэх чадалтай шинэ хэлбэрийн нэвтрүүлгүүдийг хийх боломж бололцоо олгосон” (MNB, 1997) хэмээн тухайн үеийн удирдлага болон уран бүтээлийн

багт ажиллаж байсан ахмадууд дурссан байдаг.

1980-1990 он бол Монгол телевиз дараа дараа үеийн мэргэжлийн боловсон хүчнээр эгнээгээ тэлж, нийтлэл нэвтрүүлгийн бодлого, хөтөлбөр, сүлжээний хувьд бүрэн туршлагажсан, дотооддоо мэргэжлийн бүтээлийн чанар стандарт, шалгуур үзүүлэлтүүд бий болсон, сэтгүүл зүйн салбар ухаан дотроо нэр хүндтэй, нөлөөтэй хэвлэл мэдээллийн хэрэгсэл болсон үе байв. 1980 оны 7 дугаар сард, хамгийн анх удаа спортын том арга хэмжээг хилийн чанадаас нэвтрүүлсэн нь Москвагийн зуны олимпын их наадмыг шууд дамжуулсан явдал байжээ. 1981 онд монгол хүн сансарт ниссэн түүхт үйл явдлыг сурвалжлан дамжуулсан “Сансарт хүрэх зам” цуврал нэвтрүүлгийг бэлтгэн, гуравдугаар сарын 6-31-ний өдрийг хүртэл өдөр бүр тасралтгүй цацсан нь, мөн Ардын хувьсгалын 60 жилийн ойд зориулсан “Манай жарны өгүүлэл” цуврал нэвтрүүлгийг 1980 оны 5-р сараас 1981 оны 7-р сар хүртэл бүтэн жил бэлтгэн цацсан нь Монгол телевизийн өнгөрөгч түүхийн хугацаан дахь нэг сэдвээр бэлтгэсэн хамгийн олон цуврал, хамгийн олон төрөл хэлбэртэй, хамгийн олон хүн ажилласан нэвтрүүлгүүд байжээ. Мөн “Шинэ Монголын социалист урлаг”, “Манай үеийн баатар”, “Нэг үеийнхэн” зэрэг цуврал нэвтрүүлгүүд цацагдаж, “Теле дуудлага” нэвтрүүлгийн хөдөө орон нутгийн малчид тариаланчдын дунд зохион явуулдаг болж хүрээг нь тэлсэн байдаг. Энэ нь Монгол телевиз үйл ажиллагааны хувьд жигдэрч, байгууллагын хөгжлийн хувьд төлөвшиж, тогтож ирснийг гэрчилнэ. Тэр хэрээр улс орны хөгжил, бүтээн байгуулалт, нийгмийн оюун санааны

амьдралд жинтэй хувь нэмэр оруулах болсон байна.

1980-1990 оны Монгол телевизийн түүхийг бүтээсэн нэвтрүүлгүүдийг тоймлон харвал: “Баярын мишээл” цэнгээнт хөтөлбөр, Манайд ирээрэй” хөгжмийн нэвтрүүлэг, “Теле тоншуул”, “Тахиа цаг”, “1:6”, “Редакцын томилолт” нэвтрүүлэг, хөдөөгийн хөгжил, хүн амын бодлогыг давхар үзүүлсэн “Говийн ганц айл”, “Говийн хүүхнүүд”, “Жилийн дөрвөн өнгө”, “Ахмадын ачийг мартаж болохгүй”, “Туршсаар судалсаар байх уу”, “Хариуцлага” зэрэг асуудал дэвшүүлсэн нэвтрүүлгүүд, ардын уламжлалт ахуй соёлынхоо үнэ цэнийг ухуулан таниулж, уламжлал шинэчлэл хоёрыг уялдуулан авч явахыг чухалчлах зорилготой “Ардын уламжлал”, “Дөрвөн бэрх”, “Ардын дуу хуур” цуврал нэвтрүүлгүүд, “Алтан зул” наадам, “Монгол уянга” кино концерт гээд уламжлал соёл өөрийн үндэсний уламжлалын үнэт зүйл

рүү хандсан хөтөлбөрүүд нэлээд нэмэгдсэн байна. Үүнтэй зэрэгцээд, залуучуудын амьдралд тулгамдаж буй эгзэгтэй асуудлуудыг хөндсөн, улс орны хөгжлийн явц, төр засгийн бодлого шийдвэрийн талаар санал бодлоо хуваалцах боломж олгох, залуусаа сонсох зорилготой “Залуустай ярилцах цаг”, “Залуу насаа хайрлаж яваарай”, “Хүүгийн бодол”, “Тантай ярилцах цаг”,

“Теле гүүр эчнээ уулзалт”, “Сайд хариулж байна”, “Худалдааны байгууллагаас та юу хүсдэг вэ?”, “Худалдан авагчаас та юу хүсдэг вэ?”, “Асуулт хариулт” зэрэг нэвтрүүлгүүд мэндэлж, олны анхаарлыг татах болжээ. Ингэж, нийгмийн амьдралын асуудал шийдлийн нэвтрүүлгүүд эхэлж, тоогоо нэмж, агуулгаа өргөтгөж, үзэгчдийг байлдан дагуулсан байдаг. 1987 онд “Өөрчлөн

байгуулалтын туршлага” нэвтрүүлэг, “Түүхийн өмнө хүлээх хариуцлага” нэвтрүүлэг, таван залуу хөтөлөгч ээлжлэх, зэрэгцэх, олон олон зочидтой ярилцах, хэлэлцэх, мэтгэлцэх хэлбэрээр хийгддэг байсан “Цаг үе залуучууд” нэвтрүүлэг улам бүхний анхаарлыг татаж байжээ. МУОНТ-ийн нэвтрүүлгүүд нийгэм цаг үеийнхээ оюун санааны илэрхийлэл, нийгмийн болоод хүмүүсийн оюун санааны амьдралд шинэ эрэлт хэрэгцээ бий болж буйг соргогоор мэдрэн хүлээн авагч, эргээд тухайн цаг үеийнхээ нийгмийн

оюун санааны амьдралын тусгал болж байсан нь илт байна. Энэ арван жилд, үзэгчидтэйгээ харилцан ярилцах, санал солилцох, залуу үеэ сонсох чөлөөт сэтгэлгээний нэвтрүүлгүүд, үзэл бодлоо уралдуулах, асуудал хөндөх, санал шүүмж гаргах, асуудал дэвшүүлсэн нийтлэл нэвтрүүлгүүдэд илүү их анхаарсан байна. Шинээр нэмэгдсэн нэвтрүүлгүүдийг харахад дийлэнх нь



МУОНТ-ийн нэвтрүүлгүүд нийгэм цаг үеийнхээ оюун санааны илэрхийлэл, нийгмийн болоод хүмүүсийн оюун санааны амьдралд шинэ эрэлт хэрэгцээ бий болж буйг соргогоор мэдрэн хүлээн авагч, эргээд тухайн цаг үеийнхээ нийгмийн оюун санааны амьдралын тусгал болж байсан нь илт байна. Энэ арван жилд, үзэгчидтэйгээ харилцан ярилцах, санал солилцох, залуу үеэ сонсох чөлөөт сэтгэлгээний нэвтрүүлгүүд, үзэл бодлоо уралдуулах, асуудал хөндөх, санал шүүмж гаргах, асуудал дэвшүүлсэн нийтлэл нэвтрүүлгүүдэд илүү их анхаарсан байна



нийгмийн амьдралын гүнд болж буй үйл явдлын үнэн мөнийг олж харж, илрүүлэн гаргаж, танин мэдүүлэх, нийгмийн оюун санааны амьдралын хөгжил төлөвшлийг эргэн харах хүсэл зоригийн эрэлд гарсан, алдаа оноогоо шүүн хэлэлцэх, засаж залруулах, бүх салбарт буй асуудал бэрхшээлийг уудлан гаргаж, үнэнийг илчлэх, хамтын санал бодлыг сонсох гэсэн “шүүмжлэлт” нэвтрүүлгүүд зонхилон хөгжсөн болох тодорхой байна. Нэг талаас нам төрийн бодлого үйл ажиллагааны суртал ухуулагч, үзэл суртлын зэвсэг байсан ч нөгөө талаараа хүний нийгмийн амьдралын шинэ соёлын гэрэл гэгээ, зүг чиг, итгэл үнэмшил, эв нэгдлийн бүрдэл, улс үндэстний хөгжлийн баримжаа, харьцуулалт болж байсныг үгүйсгэх боломжгүй. Тухайн цаг үеийнхээ томоохон тусгал, эргээд тухайн цаг үе нийгэм, хүмүүсийн ухамсар, соёл сэтгэлгээг төлөвшүүлэгч болсоор ирсэн Монгол телевизийн нийгмийн оюун санааны амьдралд ямар хувь нэмэр оруулж, ямар байр суурь эзэлснийг дүгнэж үзвэл, бүхий л цаг хугацаанд, хувь хүний ажил амьдралын түүхээр дамжуулан эрдэмт хүн гэж хэнийг хэлэх, сайн хүн гэж хэнийг хэлэх, боловсролтой хүн ямар байдаг, социализмыг байгуулалцаж буй хөдөлмөрч, бүтээлч хүн гэж хэнийг хэлэх, ёс суртахуун, гоо зүй, ёс зүй, урлаг соёл гэхчлэн тухайн цаг үеийнхээ үлгэр дуурайлал болох хүний дүрийг үзүүлж, тэр дүрээрээ дамжуулан тухайн нийгмийнхээ оюун санааны амьдралыг бүтээлцжээ. Телевиз нийгэм хоёр тийм л их холбоотой, харилцан хамааралтай байжээ. Телевизээс бүхнийг мэдэж авч, суралцаж, телевизээр гарсан хүнийг шүтэж, даган дуурайж, телевизийн нэвтрүүлгүүд олон нийтийг хүмүүжүүлж, хөгжүүлж, урлан бүтээж байжээ. Судлаач, доктор

Т.Баасансүрэн “Монголын үндэсний телевиз цэнхэр дэлгэцээ асааснаар монголын сэтгүүл зүйн салбарт чанарын хувьсал гарсан гэж хэлж болно. Монголын үндэсний телевиз үүсэн байгуулагдсан явдал нь зөвхөн манай сэтгүүл зүйн салбарт гарсан онцгой ололт дэвшил төдийгүй Монгол улс, монголын ард түмний оюун санааны амьдралд гарсан цоо шинэ үзэгдлийн эхлэл болсон юм” (МҮОНТ, Гэрэлт цамхаг 50 ЭШХ-ийн илтгэл, 2017) гэж тэмдэглэжээ.

Сайн тал нь нийгмээрээ нэг л зүйлд итгэн үнэмшихэд хөтөлж, итгэл үнэмшлийн үнэт зүйлийн оюун санааны нэгдмэл байдлыг бий болгож байсан явдал. Харин сөрөг тал нь хувь хүний “хүн” гэх эрх чөлөөг хязгаарлаж, ганцаараа хэн ч биш, нийтээрээ нийгмээрээ бид бүхнийг чадна. Тиймээс нийгмийн амьтан л бай гэдэг сүргийн сэтгэлгээг тулгасан явдал тухайн үеийн Монгол телевизийн нийгмийн оюун санааны амьдралд эзлэх байр суурь хэр хүчтэй байсныг 1990 оны ардчилал батлан харууллаа гэвэл хэтийдэхгүй болов уу.

1990-2005 он. Монгол телевизийн өөрийнх нь оюун санааны амьдрал олон талтай, тусгайлан судлууштай талбар болжээ. Ардчилал, ил тод байдал, олон ургалч үзэл, хүний эрх, эрх чөлөө, өөрчлөлт шинэчлэлт, зах зээл, чөлөөт эдийн засаг, олон намын тогтолцоо, парламент гээд шинэ шинэ үгнүүд, утга агуулгууд, үүрэг хариуцлагын тогтолцоонууд, мэдээ мэдээллүүд, мэдлэг ойлголтуудыг дагуулсан ардчилсан өөрчлөлтийн жилүүд Монголын улс төр, нийгэм соёл, хэвлэл мэдээллийн салбарт ч эрс шинэчлэл болж, Монгол телевизэд ч хүчтэй нөлөөлсөн. Нийгмээ өөрчлөх хүсэл зоригийн илэрхийлэл болсон олон арван нэвтрүүлэг

бэлтгэж, нийтийн сэтгэл зүйд алгуур нөлөөлж байсан телевиз эргээд өөрөө олон зүйлийн шүүмжлэлд өртөж, нэг намын үзэл суртлыг ухуулагч, магтан дуулагч зэвсэг хэмээн буруутгагдав. Үгүйсгэх боломжгүй нөхцөл байдал үүсэв. Нам төрийн бодлогыг тайлбарлан таниулах, тайлагнан дамжуулах, сурган зааварлах, сурталчлан таниулах ажил үүргийг гүйцэтгэж байсан нь үнэн учраас дангаар ноёрхсон, үзэл суртлын зэвсэг болсон гэдэг дүгнэлтийн эзэн болов. Гэсэн ч шинэ сэтгүүл зүйн хөгжлийн үзэл санаа, үүрэг хариуцлагыг хүлээн авч, дагуулж явсан нийгмээ даган хөгжих, өөрчлөгдөн шинэчлэгдэх замналыг сонгосон нь ч бас үнэн.

1 1990 онд “Монголын нууц товчоо” анхны нэвтрүүлэг хийж, телевизийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөн “Гал”, “Цацал”, “Марал” гэсэн гурван нэгдэлд хуваагдсан байна. 1991 онд Америкийн телевизийн нэвтрүүлэг хүлээн авах ёслолын ажиллагаа болжээ. Японоос анхны нэвтрүүлэг хийгдсэн байна. Анхны Бизнес шоу нэвтрүүлэг, Герман, Франц болон бусад гадаад хэлний хичээлүүд, “Шарай голын гурван хаан” жүжиг хийгдэж Монгол телевиз Ази номхон далайн орнуудын телевизийн байгууллага АВU-д гишүүнээр элссэн байна. “Агшин”, “Дөрвөн бэрх”, “Үдшийн хэмнэл”, “Харц” нэвтрүүлгүүд хийгдэж эхэлжээ. Мөн 1992 онд “Чөлөөт телевиз” хэмээх телевиз нэвтрүүлгээ эхлүүлж, “Улаанбаатар телевиз” үүд хаалгаа нээсэн байна. 1993 оноос “Цэнхэр гариг” олон улсын спорт, “Теле-бирж” анхны зар сурталчилгааны цаг, Мэдээллийн агентлаг байгуулагджээ. Мөн 1993 оноос “Урам” нийтлэл-уран сайхны нэвтрүүлэг эхэлж дэлхийн соёлыг Монголын үзэгчдэд таниулж эхэлсэн нь оюунлаг бүтээлийн оргил байжээ.

1993 оны 4 дүгээр сарын 12-нд “Радио телевизийн нэвтрүүлгийн чанарыг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 59 дүгээр тогтоол гарч, бүтцийн өөрчлөлт хийж, студийн зохион байгуулалт руу шилжиж, олон олон шинэ телевиз байгуулагдах үндэс тавигдаж, олон улсад өрсөлдөх болсон. Ингэж сэтгүүл зүйн суурь зарчим, телевизийн мэргэжлийн үйл ажиллагаа, үнэт капитал болсон боловсон хүчний нөөц, нэр хүндийн баталгаагаараа бодит тусалцаа үзүүлсэн, одоо ч энэ байдал үргэлжилсээр байдаг. Энэ бол чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлж, ардчилал хүний эрхийг дээдэлсэн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эхлүүлэхэд оруулсан жин дарах хувь нэмэр юм. Нийгмийн байгууллын хувьд ямар улс орон болж байгааг тодорхойлж, хуульчлан тогтоож өгсөн Монгол улсын шинэ Үндсэн хууль 1992 онд батлагдсаны дараа Монголын ХМХ-ийн хувьд эцэг хууль гэгддэг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль батлагдсан юм. ХМХ-ийг төрийн эрх мэдлийн хараат байдлаас салгах, хувийн хийгээд олон нийтийн өмчлөлд шилжүүлэхээр тогтсон нь тухайн үеийн нийгмийн оюун санааны амьдралд тохиосон том үйл явдал үзэгдэл, төр иргэн хоёрын ойлголцол, нэгдлийн уулзвар болсон харагддаг. Гэвч яг одоогийн байдлаар нийгмийн оюун санаанд нөлөөлөх телевизүүдийн нөлөөлөл нь сөрөг үү, эерэг үү гэдгийг судалж, үнэлж дүгнэх хэрэгтэй болжээ.

2005-өнөөдрийг хүртэл. 2005 онд батлагдсан ОНРТ-ийн тухай хуулиар олон нийтийн статустай радио, телевизийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тавьж, бодлого үйл ажиллагааны чиглэл, хил хязгаарыг тогтоож өгсний дагуу Засгийн газрын харьяанд Радио, телевизийн хэрэг эрхлэх газар

нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан үндэсний хэмжээний радио, телевизийн байгууллагыг 2006 оны 2-р сарын 15-ны өдөр Монголын Үндэсний Олон нийтийн Радио, Телевиз болгон монголын олон нийтийн статустайгаар өөрчлөн зохион байгуулсан юм. Энэ бол Монголын нийгмийн оюун санааны амьдралд тохиосон түүхэн үйл явдал байсан. Энэ тухайд “төрийн эрх мэдэлд байсан телевизийг олон нийтийн эрх мэдэлд өгч, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, чөлөөт хэвлэл мэдээллийн үзэл санаа, үнэт зүйл, соёл, мэргэжлийн сэтгүүл зүйн зарчимд суурилсан нийгмийн томоохон үзэгдэл мөн” (Л.Норовсүрэн, 2019). Өнөөгийн байдлыг харвал хувийн арилжааны ХМХ-ийн өмчлөгч эзэд чөлөөт хэвлэлийн хөгжлийн асуудалд учир дутагдалтай хандаж, хувийн болоод хэсэг бүлгийн хүсэл сонирхлыг төлөөлүүлэх хандлага ажиглагдахын зэрэгцээ “олон нийтийн эзэмшлийн” буюу үндэсний олон нийтийн гэх хаягтай телевиз нь төр засаг хийгээд улс төрийн намын нөлөөнөөс ангижирч чадаагүй хэвээр байна. Энэ тухайд “Зах зээлийн хувьд маш жижиг буюу гурван сая хүн амд хэвлэл мэдээллийн 500 шахам хэрэгсэл оногдож буй нь багтаамжаасаа хол хэтэрсэн үзүүлэлт бөгөөд хэвлэл мэдээллийн зах зээл дээр санхүүгийн ашиг олох үүднээс бус өөр ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тэдгээрийг байгуулан, хөрөнгө оруулж байгаагаар үүнийг тайлбарлаж болно” хэмээн 2016 онд Монголын хэвлэлийн хүрээлэн, “Хил хязгааргүй сэтгүүлчид” байгууллагын хамтран судалгаанд тэмдэглэжээ. 1990 онд Ардчиллын үйл явц өрнөхөд “Монголын нийгмийн оюун санаа”-нд дахин шинэ хувьсал гарч ардчилал нэрийн дор анархист нийгмийн оюун санаа бүрдэж

эхэлсэн. Эс бөгөөс өмнөх 1900-гаад оны оюун санааны амьдралын хөрс суурь нь ил гарч ирсэн. Аль нь үнэн болохыг харьцуулан судалсан зүйл алга. Итгэн үнэмшиж байсан социализм үгүй болчихоор түүнээс өмнө ямар байсан тэр цаг үеийнхээ оюун санааны амьдрал руу буцсан ч байж болно. Франц, Итали, Германаас уламжлалтай фрейд-марксизм, экзистенциалист-марксизм буюу “нео-марксизм”-ын онолын үе шатыг алгасаад шууд хүмүүнлэг ардчиллын замд орчихсон нь оюун санааны асар том эргэлзээ тээнэгэлзээг бий болгосон. Энэ эргэлзээ одоо ч арилаагүй учраас монголчууд өөрсдийгөө хэн байх ёстойг, хүүхдүүдээ хэрхэн хүмүүжүүлэх ёстойгоо, юуг эрхэмлэх ёстойгоо, юунд итгэж үнэмшиж буйгаа, ямар үнэт зүйлтэй гэдгээ тодорхойлж чадахгүй явсаар байна.

Монголын нийгмийн оюун санааны амьдралд тулгарсан энэхүү ойлгомжгүй байдал ХМХ-үүдэд ч, МҮОНТ-ийн бодлого үйл ажиллагаанд ч нөлөөлсөн. Энэ бүхнээс яг одоо Монголын нийгмийн оюун санааг хэн хэрхэн яаж чиглүүлж, хэний ямар оюун санаа Монголд ноёрхож байна вэ? гэдгийг тодруулах тухай асуудал чухлаар тавигдана. Монголын нийгмийн оюун санааны амьдралыг хэн удирдаж байна вэ? Бид нийгмээрээ, улс орноороо хаашаа чиглэж явна вэ? Нийгмийн оюун санааг бүрдүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэдэг хэвлэл мэдээллийнхний тухай философич С.Батчулуун: “Монголын нийгмийн оюун санааны хоосон орон зайг эзэгнэсэн гадныхан, тэдний гар хөл болсон улс төрчид, улс төрчдийн гар хөл болсон хэвлэлийнхэн гэсэн мистицизм, монгол эмэгтэйчүүдийн ажилгүйдлийг нөхсөн сүлжээний бизнес, монгол залуусын амьдралын мөрөөдөл болсон гадаадад ажиллах

гэсэн үндсэн гурван зүйлд тулгуурласан хүсэл тэмүүлэл бүтэн үндэстний хүсэл тэмүүлэл шиг болтлоо хэлбэршин тогтож, нийгмийн оюун санааны амьдралыг тодорхойлж байна. Энэ байдал өөрчлөгдөх нь цаг хугацааны асуудал хэдий ч үлдэх мөр, өгөх хор хохирол нь багагүй юм. Нийгмийн оюун санааны амьдрал нь ийм арчаагүй өрөвдөм, нэгдэх үнэт зүйлгүй, нийлэх итгэл үнэмшилгүй, үнэн худал, зөв бурууг ялгахгүй хэмжээний ёс суртахуунд хүрч байгааг олж харсан гадныхан дур зоргоороо аашилна. Удирдана, тоглоом тохуу хийнэ. Тэднийг ингэж нийгмийн оюун санааны амьдралын хоосон орон зайд эзэн суухад нь дэмжин туслагчид бол бас л хэвлэл мэдээллийнхэн. Ингэж ямар ч “иргэний соёл” байхгүй нийгмийн оронцогтой боллоо. Энэ нийгэмд одоо, дутуу боловсорсон ардчилагчид, эрэмдэг зэрэмдэг либералууд, дундад зууны үндэстний үзэлтнүүд, коммунист угшилтай социалистуудаас өөр хүн алга” (С.Батчулуун, 2008) хэмээн бичжээ.

Эндээс хүмүүс яг ямар нийгмийг хүсдэг вэ? МҮОНТ энэ бүхний хаана нь байх ёстой вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Хариулт нь, хүмүүс хүсэж байгаа нийгэм шигээ оюун санаатай байж чадаагүй учраас хүсэж байгаа нийгэмээ бүтээж чадахгүйд хүрдэг гэсэн сануулга болж байна. Хүмүүс ямар нийгэмд амьдарч байна яг түүн шигээ оюун санаатай болчихдог. Тэгэхээр МҮОНТ-ийн бодлого үйл ажиллагаа хүмүүсийн оюун санаа руу хандах нь хамгийн зөв сонголт, хамгийн том хүлээх үүрэг хариуцлага нь мөн. Нийгмийн оюун санааны амьдралыг тухайн үндэстний түүхэн ой санамж, цаг хугацаа орон зайнаас үл хамааран өвлөгддөг мэдлэг ухаан, энэ цагийнхны ажил амьдрал оюун сэтгэлгээний дүр зураг, өнгөрсөн хийгээд ирээдүйдээ

хандах хандлага ухамсар, соёл сэтгэлгээ илэрхийлэн хэлбэржүүлж байдаг бөгөөд түүнийг хэрэгжүүлэх эзэд нь тухайн улс үндэстний оршин буйн баталгаа болсон төр, ард түмэн гэсэн хоёр субъект байх нь гэсэн оюуны зураглал гаргаж, үүнийг бүрдүүлэхийн төлөө ажиллахад бодлого үйл ажиллагаагаа зориулах үүргийг МҮОНТ-д хуулиар хүлээлгэжээ хэмээн үзэж байна.

Эшлэл

1. Дожоодорж, Д. нар. 1997. Зурагт зулын хойморт заларсан нь. УБ., х.147.
2. Дожоодорж, Д. нар. 1997. Зурагт зулын хойморт заларсан нь. УБ., х.160.
3. МҮОНТ-ийн 50 жилийн ойд зориулсан “Гэрэлт цамхаг 50” нэвтрүүлэг. 2017.
4. МҮОНТ-ийн 50 жилийн ойд зориулсан “Гэрэлт цамхаг 50” нэвтрүүлэг. 2017.
5. Норовсүрэн, Л. 2019. “Сэтгүүл зүй” цуврал. Боть XII. УБ., х.128.
6. Батчулуун, С. 2008. “Бууны нохой” юу, “хоточ нохой” юу?! өгүүлэл. “Цаг төр, хүмүүс” сэтгүүл. www.news.mn

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Байгалмаа, Д. 2018. Монголын радиогийн хөтөлбөр, нийтлэл нэвтрүүлгийн бодлого (магистрын судалгааны ажил).
2. Батчулуун, С. 2008. “Бууны нохой” юу, “хоточ нохой” юу?! өгүүлэл. “Цаг төр, хүмүүс” сэтгүүл. www.news.mn
3. Дожоодорж, Д. нар. 1997. Зурагт зулын хойморт заларсан нь. УБ.
4. МҮОНТ-ийн 50 жилийн ойд зориулсан “Гэрэлт цамхаг 50” нэвтрүүлэг. 2017.
5. Норовсүрэн, Л. 2019. “Сэтгүүл зүй” цуврал. Боть XII. УБ.

Summary

The development path of the MNB since 1967 also has a history of successes and failures during that time. Mongolian television, which worked on all social problems of all times on air, and gave its voice in all aspects, produced new heroes with its

news, articles, and programs. It is an expression of morality, knowledge, education, learning ability, goal, ability ranking, talent, effort, potential, worldview, and development status, and remains of an archival document that would sew times together. 2022 marks the 55th anniversary of the MNB. There is a legitimate need to evaluate the role, influence,

participation, and position occupied by the half-century-old television in the spiritual life of Mongolian society, to objectively review the current situation, to make an accurate assessment, and to formulate a new development plan.